# ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2016 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

| № | Хийх ажлын агуулга | Шалгуур<br>Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хийсэн ажил |
|---|---|---|---|
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 5.1.2;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.5;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.1.2. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/ | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалтны хувийн ашг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам"-ыг яамны mrtd.gov.mn/erhzui/1 цахим хуудсанд, хөрөнгө орлогын цахим мэдүүлгийн холбоосыг mrtd.gov.mn/ цахим хуудсанд тус тус байрлуулав.<br>Мөн тус яамны "Мэдээллийн цаг" арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 2016 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх нь" сэдвээр АТГ-ын ажилтан н.Мөнхжаргал лекц уншиж, яамны албан хаагч нарт авлига, ёс зүйн асуудлаар тодорхой мэдээлэл хийв. |
| | | Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх | АТГ-аас хүргүүлсэн "Шударга нийгмийн төлөө хамтдаа" сурталчилгааны зурагт хуудаснуудыг иргэд, байгууллага, албан хаагчдад зориулан яамны 1 болон 3 дугаар давхарт байршуулав. |
| 2 | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6.1.2;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.5. | Яамнаас санаачлан боловсруулж байгаа Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Авто тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, бусад хуулийн төсөл болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх | Тус яамнаас санаачлан боловсруулж байгаа Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Авто тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулга, Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг mrtd.gov.mn/all/104 цахим хуудсанд байршуулан, иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн саналыг хүлээн авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.<br>Мөн mcaa.gov.mn/?page_id=12266 цахим хуудсаар Иргэний нисэхийн дүрмийн төслүүдэд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн саналыг хүлээн авч байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Яамнаас санаачлан боловсруулж байгаа Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Авто тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, бусад хуулийн төсөл болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх | Тус яамнаас санаачлан боловсруулж байгаа Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Авто тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулга, Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд болон Иргэний нисэхийн дүрмийн төслүүдэд иргэд, олон нийт, сонирхогч бүлгээс санал ирээгүй болно. |
| | | Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байх | |
| 3 | Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6.1.3<br>• Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.17 | Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулсан байх | 2016 оны хяналт шалгалтын календарчилсан төлөвлөгөө: http://mrtd.gov.mn/all/87 |
| | | Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх /цахим хуудсаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх/ | Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх http://mrtd.gov.mn/all/87 |
| | | Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх | Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/<br>http://mrtd.gov.mn/all/87 |
| 4 | Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6.1.4;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл | 2016 оны төсөв | 2016 оны төсөв:<br>shilendans.gov.mn/org/418?group=0&year=2016 |
| | | 2015 оны төсвийн гүйцэтгэл | 2015 оны төсвийн гүйцэтгэл:<br>shilendans.gov.mn/org/418?form=333664&year=2015&group=0&task=738 |
| | | Сарын төсвийн гүйцэтгэл | Сарын төсвийн гүйцэтгэл:<br>shilendans.gov.mn/org/418?form=1041500&year=2016&group=0&task=738 |
| | | Улирлын төсвийн гүйцэтгэл | Улирлын төсвийн гүйцэтгэл:<br>shilendans.gov.mn/org/418?form=549301&year=2016&group=0&task=738 |
| | | Хагас жилийн төсвийн гүйцэтгэл | Хагас жилийн төсвийн гүйцэтгэл:<br>shilendans.gov.mn/org/418?form=832210&year=2016&group=0&task=738 |
| | | Хагас жилийн санхүүгийн тайлан | 2016 оны хагас жилийн санхүүгийн тайлан: |

| | | | |
|---|---|---|---|
| | | | shilendans.gov.mn/org/418?form=963430&year=2016&group=0&task=738 |
| | | Дараа жилийн төсвийн төсөл | Дараа жилийн төсвийн төсөл: shilendans.gov.mn/org/418?form=947665&year=2016&group=0&task=738 |
| | | Жилийн эцсийн санхүүгийн тайлан | Жилийн эцсийн санхүүгийн тайлан: shilendans.gov.mn/org/418?form=432362&year=2015&group=0&task=738 |
| | | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт: shilendans.gov.mn/org/418?form=432420&year=2015&group=0&task=738 |
| | | Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ: shilendans.gov.mn/org/28?form=869907&year=2016&group=2&task=19 |
| | | Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар | Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар: shilendans.gov.mn/org/418?form=1041500&year=2016&group=0&task=738 |
| | | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт: shilendans.gov.mn/org/418?form=1041509&year=2016&group=0&task=738 |
| | | Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/ | улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл: shilendans.gov.mn/org/28?form=304467&year=2016&group=0&task=19 |
| | | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт: shilendans.gov.mn/org/418?form=394417&year=2016&group=2&task=738 |
| | | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт: shilendans.gov.mn/org/418?form=995670&year=2016&group=0&task=738 |
| | | Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт | Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт: shilendans.gov.mn/org/418?form=998261&year=2016&group=2&task=738 |
| | | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, |

| | | | |
|---|---|---|---|
| | | хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр | концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр: shilendans.gov.mn/org/28?form=997181&year=2016&group=2&task=19 |
| | | Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт /тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт/-ыг цахим хуудсандаа байршуулах | Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг mrtd.gov.mn/human цахим хуудсанд байршуулав. |
| | | Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт /тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт/-ыг цахим хуудсанд төрийн байгууллага бүрээр байршуулах | Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг Зам, тээврийн хөгжлийн яамны mrtd.gov.mn/human цахим хуудсанд байршуулав. |
| | | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр:<br>- Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх 2 дахь үе шат цаг /АХБ/ shilendans.gov.mn/org/5749<br>- Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл /MON-0240/ shilendans.gov.mn/org/4947<br>- УБ хотын олон улсын шинэ нисэх буудал барих төсөл shilendans.gov.mn/org/4948<br>- Гудамж төсөл shilendans.gov.mn/org/5746 |
| 5 | Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6.1.5;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.8 | Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /*тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл*/-ийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах | Зам, тээврийн яамнаас олгож буй тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл: mrtd.gov.mn/single/94/item/361,<br>srd.mcaa.gov.mn//index.php?option=com_content&task=category&sectionid=16&id=92&Itemid=117 |
| | | Дээрх зөвшөөрөл /*тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл*/-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулах | Дээрх тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журам<br>mrtd.gov.mn/all/23,<br>mrtd.gov.mn/all/25,<br>srd.mcaa.gov.mn//index.php?option=com_content&task=category&sectionid=16&id=92&Itemid=117 |
| | | Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах | Зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацаа<br>mrtd.gov.mn/single/23/item/315<br>mrtd.gov.mn/single/25/item/343<br>srd.mcaa.gov.mn//index.php?option=com_content&task=category&sectionid=16&id=92&Itemid=117 |
| | | Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгох | Зам, тээврийн сайдын 2012 оны 59 дүгээр тушаалаар баталсан “Автотээврийн хэрэгслийн гэрчилгээний бүртгэл хөтлөх, улсын |

| | | | |
|---|---|---|---|
| | | | дугаар олгох журам"-д заасны дагуу авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын бүртгэл mrtd.gov.mn/erhzui/5 |
| 6 | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6.1.5;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл | Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн/<br><br>Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх | Тус яамны цахим хуудсанд 2016 онд дараах сул орон тооны зарыг байршуулж олон нийтэд хүргэсэн. Үүнд:<br>1.Зам, тээврийн яамны агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын зар,<br>2."Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл"-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн Эд хөрөнгө хариуцсан мэргэжилтний ажлын байранд ажилтан шалгаруулж авах зар.<br>Дээрх зарын дагуу сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргасан иргэдийн материалыг хүлээн авч, сонгон шалгаруулалтыг холбогдох журам, зааврын дагуу зохион байгуулж, шалгарсан иргэнийг тухайн албан тушаалд томилон ажиллуулсан.<br>Түүнчлэн тус яаманд 2016 онд гарсан бусад ажлын байрны сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.4-т заасныг үндэслэн төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас нэр дэвшүүлэн сонгон шалгаруулах, төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс нэр дэвшүүлэх замаар нөхөх арга хэмжээ авсан болно. |
| 7 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6.1.4;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл<br>• Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47.4, 48.5 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө:<br>mrtd.gov.mn/tender/83/item/595<br>shilendans.gov.mn/org/418?form=94416&year=2016&group=1&task=738 |
| | | Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх | Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журмыг mrtd.gov.mn/single/83/item/554 цахим хуудсанд байршуулав.<br>Тендерийн урилгыг mrtd.gov.mn/tender болон e-procurement веб сайт болон үндэсний хэмжээний өдөр тутмын "Өдрийн сонин" сонинд нийтлэв. |
| | | Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулах | Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан:<br>shilendans.gov.mn/org/418?form=396928&year=2016&group=1&task=738 |
| | | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, |

| | | | |
|---|---|---|---|
| | | нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах | нийлүүлэгчийн нэр, хаягийг shilendans.gov.mn/org/418?form=831753&year=2016&group=1&task=738 цахим хуудсанд байршуулав. |
| | | Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах | Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн: shilendans.gov.mn/org/418?form=1010137&year=2016&group=2&task=738 |
| | | Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх | Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын тус бүр хоёр доошгүй төлөөллийг оролцуулж ажилласан. |
| 8 | Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6.1.6 | Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх<br><br>Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох | - Тус яам нь Засгийн газрын бүтцийн тухай 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн Монгол Улсын хуулийн дагуу шинээр байгуулагдсан бөгөөд “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” Засгийн газрын 2016 оны 03 дугаар тогтоолын дагуу 6 газар, 1 хэлтэс, 145 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Батлагдсан бүтэц, орон тооны дагуу тус яамны 5 газар, 1 хэлтсийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, ажлын байрны жагсаалт болон нийт 139 ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 02 дугаар тушаалаар баталсан болно.<br>- Тус яамны албан хаагчдын овог, нэр, хариуцаж буй ажил үүргийн талаарх мэдээлэл, холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаягийн хамт тус яамны цахим хуудсанд mrtd.gov.mn/*ил тод байдал/хүний нөөцийн ил тод байдал/туслах цэс/албан хаагчдын жагсаалт”* хэсэгт байршуулж байна. |
| 9 | Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.3 | Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх */1 ба түүнээс дээш/*<br><br>Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгасан байх<br><br>Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх | “Авто зам барих, засварлах тусгай зөвшөөрөл олгох журам”-ын дагуу иргэн, аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч мэргэжлийн дүгнэлт гаргах чиг үүргийг “Автозамчдын нэгдсэн холбоо” ТББ-аар гүйцэтгүүлж байна.<br>Түүнчлэн яамнаас байгуулсан ажлын хэсэг, комисс, зөвлөлд холбогдох төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах нөхцлийг хангаж ажиллаж байна. Тухайлбал, худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороонд төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан ажиллуулж байна. Мөн төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр тус яамнаас “Автозамчдын нэгдсэн холбоо”, “Төмөр замчдын нэгдсэн холбоо”, “Автотээвэрчдийн нэгдсэн холбоо”, “Агаарын |

| | | | |
|---|---|---|---|
| | | | тээвэрлэгчдийн нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. |
| 10 | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6.1.8;<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.2 | Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг томилсон байх | “Ажил хариуцуулах тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2012 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 158 дугаар тушаалаар албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хүлээн авах, бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажлыг тус яамны ТЗУХЭЗГ-ын ахлах мэргэжилтэн Д.Жавхланд хариуцуулсан. |
| | | ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх | Эрх бүхий албан тушаалтны /ЭБАТ/ буюу тус яамны ТЗУХЭЗГ-ын ахлах мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг нарийвчлан тогтоож өгсөн. |
| | | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх | Авлигатай тэмцэх газраас 2016 оны 01 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд зохион байгуулсан ЭБАТ-уудад зориулсан нэгдсэн сургалтад тус яамны ЭБАТ оролцов. |
| | | ЭБАТ-ын үйл ажиллагааг үнэлэх | АТГ /ХШДШХ/-ын үнэлгээ байна. |
| 11 | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг со-нирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл;<br>• Авлигын эсрэг хуулийн 6.1.9, 6.8, 6.1.6 | Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх /албан хаагчдад танилцуулсан байдал/ | Монгол Улсын төрийн албан хаагчдын эрхэмлэх есөн зүйл, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм болон Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журмыг mrtd.gov.mn/human/type/41 цахим хуудсанд байршуулсан бөгөөд Ёс зүйн хороонд 2016 онд зөрчлийн талаар гомдол ирээгүй.<br>Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байгаа ба 6226-3179 дугаарын утсаар, 312315 факсаар, mrtd.gov.mn цахим хуудасны “санал хүсэлт” булангаар, 11-11 төвөөр болон бичгээр, амаар иргэдээс өргөдөл, гомдлыг хүлээн авч байна.<br>Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тухай мэдээг хагас, бүтэн жилээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн ажиллаж байна. |
| | | Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /*тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м*/-ийг бүр-дүүлсэн байх | |
| | | Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/-г авах | |
| | | Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх | |
| | | Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх | |
| 12 | Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх | Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байх | Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалт:<br>mrtd.gov.mn/human/41/item/551 |

| | | | |
|---|---|---|---|
| | ***Эрх зүйн үндэслэл:***<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.6, 19 дүгээр зүйл | Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог байх | Тус яаманд өнөөдрийн байдлаар давхар ажил эрхэлж байгаа албан тушаалтан байхгүй болно. |
| 13 | Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6.1.10;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.4, 9.1.5 | Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх, удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэрийг цахим хуудсандаа байршуулах | Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлж, mrtd.gov.mn/erhzui/5 цахим хуудсанд Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалуудыг байршуулав. |
| | | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, заавар цахим хуудсандаа байршуулах | Үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журмын жагсаалт, зааврыг<br>mrtd.gov.mn/erhzui/1<br>mrtd.gov.mn/erhzui/2<br>mrtd.gov.mn/erhzui/3<br>mrtd.gov.mn/erhzui/4<br>mrtd.gov.mn/erhzui/5<br>mrtd.gov.mn/erhzui/6<br>mrtd.gov.mn/erhzui/7<br>mrtd.gov.mn/all/103 цахим хуудсанд байршуулав. |
| | | Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах | Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн жагсаалт: mrtd.gov.mn/single/94/item/362 |
| 14 | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6.1.11;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.2;<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.3; | Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр) | Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байгаа ба 6226-3179 дугаарын утсаар, 312315 факсаар, mrtd.gov.mn цахим хуудасны “санал хүсэлт” булангаар, 11-11 төвөөр болон бичгээр, амаар иргэдээс өргөдөл, гомдлыг хүлээн авч байна. |
| | | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг http://mrtd.gov.mn/contact цахим хуудсанд байршуулав. |
| | | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар цахим хуудсанд тогтмол хугацаанд мэдээлсэн байх | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн байдал /улирал бүрээр/ http://mrtd.gov.mn/all/107 |

| | | | |
|---|---|---|---|
| | • Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэх тухай хуулийн 7.8, 7.9, 19.3 | | |
| 15 | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6.1.12;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.1.1 | Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх | Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалт:<br>mrtd.gov.mn/human/41/item/552 |
| | | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/ | Зам, тээврийн салбарын хэмжээнд авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх хүрээнд байгууллагын дотоод хяналт, шалгалтыг чангатгаж “Сахилга хариуцлагыг сайжруулж, ажил эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” Төрийн нарийн бичгийн даргын тушаал гаргасан бөгөөд энэхүү тушаал нь нийт албан хаагчид хууль тогтоомжийг чанд мөрдөж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хариуцлагыг сайжруулахад чухал нөлөө үзүүлэх юм.<br>Мөн Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйл болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тус яамны албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, их хэмжээний өөрчлөлтийн мэдүүлгийг холбогдох маягтуудын дагуу хугацаанд нь гаргуулан авахаас гадна тус яаманд шинээр томилогдохоор нэр дэвшсэн этгээдүүдийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, худалдан авах ажиллагаа, хяналт шалгалт хийх, захиргааны акт гаргахад албан тушаалтны ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбарыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хүлээн авч, бүртгэн, хяналт тавин ажиллаж байна. |
| 16 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6.6, 6.7, 18.4.2, 29.4;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.2 | Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ<br><br>АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ<br><br>АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ | Авлигатай тэмцэх газрын Мөрдөн байцаагчийн 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 09 болон 10 дугаар мэдэгдлийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>1/ Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д заасан захирах, захирагдах ёсны зарчим болон 13 дугаар зүйлийн 13.1.5-д заасан төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахих, мөн Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хэрэгжүүлэх хүрээнд тус яамны хэмжээнд Баасан гараг бүр |

| | | | |
|---|---|---|---|
| | | | “Мэдээллийн цаг”-ийг зохион байгуулж, уг мэдээллийн цагаар хууль тогтоомжийн талаарх сургалт, сурталчилгаа хийж албан хаагчдийнхаа мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж байна.<br>2/ Тус яамны албан тушаалтнууд “Улсын комисс”-д ажиллахдаа Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.12.1-д заасан “Комисс нь Барилгын тухай хууль, барилгын норм, нормативын бичиг, баримтад заасан шаардлагыг хангасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах үүрэг хүлээнэ.” гэснийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт, шалгалт тавьж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>3/ Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйл болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тус яамны 175 албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, их хэмжээний өөрчлөлтийн мэдүүлгийг холбогдох маягтуудын дагуу гаргуулан авахаас гадна тус яаманд шинээр томилогдохоор нэр дэвшсэн 123 этгээдийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, худалдан авах ажиллагаа, хяналт шалгалт хийх, захиргааны акт гаргахад албан тушаалтны ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай 30 мэдэгдэл, тайлбарыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хүлээн авч, бүртгэн, хяналт тавин ажиллаж байна.<br>4/ Мөрдөн байцаагчийн мэдэгдлийн дагуу гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгаж, цаашид салбарын хэмжээнд авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх хүрээнд байгууллагын дотоод хяналт, шалгалтыг чангатгаж “Сахилга хариуцлагыг сайжруулж, ажил эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” Төрийн нарийн бичгийн даргын тушаал гаргасан бөгөөд энэхүү тушаал нь нийт албан хаагчид хууль тогтоомжийг чанд мөрдөж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хариуцлагыг сайжруулахад чухал нөлөө үзүүлнэ. |
| | | АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт | Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн дарга Л.Пүрэвбаатар, мөн тус нийгэмлэгийн Удирдлагын асуудал хариуцсан замын орлогч дарга |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Л.Даваапил нарт хариуцлага тооцож, хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2016.03.10-ны өдрийн 01/1564 тоот албан бичгийг харьяаллын дагуу 2016.03.15-ны 01/1017 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн Ерөнхий хорооны орлогч дарга Г.Ганболдод холбогдох арга хэмжээ авч ажиллахыг хүсч шилжүүлэв. |
| | | Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгосон эсэх | Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэр байхгүй болно. |
| | | АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам"-ыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т дурдсан сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан байхгүй болно. |
| 17 | Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.5, 7.6.1, 7.6.2; | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байх | Авлигын эсрэг үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөө: mrtd.gov.mn/all/87 |
| | | Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн байх | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга цаг хугацаандаа хэрэгжсэн бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийг 2016.11.14-ний өдрийн 05/1621 тоот албан бичгээр АТГ-т хүргүүлэв. |
| | | Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаа /жил бүрийн 11 сарын 15-ны дотор/-нд АТГ-т хүргүүлсэн байх | |
| | | Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх | Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл байхгүй. |
| 18 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдсэн байдал | Авлигын эсрэг төрийн бус байгууллагаас гаргаэсан санал, санаачилгыг дэмжиж, Төрийн нарийн бичгийн дарга "Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчид авлигын эсрэг санал санаачлагыг дэмжигч байж, авлигыг үл тэвчих ёс зүйтэй хамт олон байх болно" гэсэн уриалга гаргав. Уриалгыг яамны вэв сайт mrtd.gov.mn/single/87/item/344 болон мэдээллийн самбарт байрлуулж олон нийтэд хүргэв. |
| | | Удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, санаачилга, тэдний үлгэр жишээ байдал | Төрийн нарийн бичгийн дарга "Зам, тээврийн яамны албан хаагчид авлигын эсрэг санал санаачлагыг дэмжигч байж, авлигыг үл тэвчих ёс зүйтэй хамт олон байх болно" гэсэн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | уриалга гаргав. Уриалгыг яамны вэв сайт mrtd.gov.mn/single/87/item/344 болон мэдээллийн самбарт байрлуулж олон нийтэд хүргэв. |
| | | Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан эсэх /зарцуулалт/ | Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө, мөнгө төлөвлөөгүй боловч яамны аппаратын урсгал зардлаас бичгийн цаас, принтерийн хор гэх мэт зардлууд гарсан болно. |
| | | Удирдлагын хүсэл, эрмэлзлэл, хүчин чармайлт, үлгэр жишээ байдлын талаар ажилтнуудаас өгсөн үнэлгээ | “Шинжээчдийн баг”-аас тусгайлан боловсруулсан санал асуулгаар үнэлэх |
| 19 | Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх | Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/-г авах | Тус яамны “Мэдээллийн цаг” арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 2016 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх нь” сэдвээр АТГ-ын ажилтан н.Мөнхжаргал лекц унших, яамны албан хаагч нарт авлига, ёс зүйн асуудлаар тодорхой мэдээлэл хийв. |
| | | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авсан арга хэмжээ | -Яамны төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”, “Менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын дагуу хийж гүйцэтгэж байна. Яамны хөдөлмөрийн дотоод журам болон Төрийн албаны зөвлөлөөс баталсан үр дүнгийн гэрээг дүгнэх журамд заасны дагуу ажлын үр дүнгээр нь урамшуулах асуудлыг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар тухай бүр шийдвэрлэж урамшуулал олгох ажил тогтмол хийгдэж байна.<br>Мөн яамны дотоод журмын 10.5-д “Нэгжийн даргын үнэлсэн үнэлгээ болон мөнгөн урамшуулал олгох саналыг Төрийн захиргааны асуудал хариуцсан нэгжид хагас жилийн болон оны эцсийн сүүлийн сарын 20-ны дотор өгнө. Хагас жилийн болон жилийн эцсийн үр дүнгийн гэрээний үнэлгээг үндэслэн албан хаагчид албан тушаалын цалингийн 80-100 хүртэл хувийн урамшуулал олгоно”, 10.6-д “Албан хаагчдад улирлын ажлын үр дүнг нь харгалзан шууд харъяалах нэгжийн даргын саналаар албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийн урамшуулал олгоно” гэж тусгагдсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн улирал бүр урамшуулал олгосон болно. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ | Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил байхгүй. |
| | | Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ | Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил байхгүй. |
| | | Шүүхээр шийдэгдсэн Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчил | Шүүхээр шийдэгдсэн Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчил байхгүй. |

***ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ***